



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар М/362

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас барилга техник хяналтыг хэрэгжүүлэхэд гарсан албан хаагчдын томилолт, гэрээт ажилчдын цалин хөлс, лабораторийн багаж хэрэгсэл баталгаажуулалтын үнэ, шатахуун, сэлбэг хэрэгсэл, мэргэжилтэнүүдийн сургалтын зардал болох нийт 42,560,000 (дөчин хоёр сая таван зуун жаран мянга) төгрөгийг зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0706

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 26 дугаар
сарын 07-ны өдрийн 416 дугаар
захирамжийн хавсралт



ЗАХИАЛАГЧ ХЯНАЛТЫН ЗАРДЛААС САНХҮҮЖҮҮЛЭХ
АЖЛЫН ЖАГСААЛТ

Д/д	Зардлын нэр	Зардлын дүн
1	Албан хаагчдын томилолтын зардал	10,550,000
2	Гэрээт ажилчдын 8 сарын цалин, хөлс	14,850,000
3	Албан хаагчдын мэргэшүүлэх сургалтын төлбөр	2,500,000
4	Авто машины засварын үнэ	5,750,000
5	Барилгын материалын лабораторийн багаж баталгаажуулалтын үнэ	1,500,000
6	Томилолтоор ажилласан шатахууны зардал	7,410,000
	Нийт дүн	42,560,000

-оОо-